

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2024/40/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: У.Ербол
	Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Төсвийн захирагч



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА, ДЭД
ХУРАНДАА З.АЗАТ ТАНАА

2024.02.05 № 21
танай _____ -ны № _____ -Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, түүнтэй холбоотой төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гамшгаас учирсан хор уршгийг арилгах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, замын сангаас 40.6 сая төгрөг, Онцгой байдлын ерөнхий газраас 42.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч гамшгийн арга хэмжээнд зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,222,662,465.89</u>	<u>1,316,588,804.69</u>
34	УРЬДЧИЛГАА	40,000,000.00	54,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	40,000,000.00	54,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,182,662,465.89	1,262,588,804.69
351	Түүхий эд материал	874,200,927.64	913,182,728.44
35110	Тусгай зориулалттай материал	812,060,058.24	852,242,059.04
35130	Эм боох материал	62,140,869.40	60,940,669.40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	173,017,282.25	182,306,230.25
354	Хангамжийн материал	134,594,256.00	166,249,846.00
35410	Бичиг хэргийн материал	4,391,335.00	4,161,395.00
35420	Аж ахуйн материал	62,979,984.00	62,979,984.00
35430	Сэлбэг хэрэгсэл	14,719,063.00	21,641,713.00
35440	Түлш, шатах тослох материал	6,078,800.00	23,988,700.00
35450	Барилгын засварын материал	1,686,750.00	6,446,750.00
35460	Хүнсний материал	-	728,480.00
35470	Бусад хангамжийн материал	44,738,324.00	46,302,824.00
35600	Мал амьтад	850,000.00	850,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,242,921,732.01</u>	<u>5,719,440,067.25</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,242,921,732.01	5,719,440,067.25
392	Биет хөрөнгө	5,455,892,732.01	4,932,411,067.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,839,188,201.03	4,893,538,201.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,945,827,237.70)	(2,126,042,847.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,022,832,882.00	4,100,832,882.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,483,084,369.87)	(1,958,912,779.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	984,237,014.80	984,237,014.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(970,390,893.49)	(979,229,918.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,976,100.73	28,575,100.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,038,965.49)	(22,186,586.51)
39214	Бусад үндсэн хөрөнгө	78,769,130.20	90,769,130.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(78,769,130.20)	(79,169,130.20)
393	Биет бус хөрөнгө	787,029,000.00	787,029,000.00
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(250,000.00)	(250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	787,029,000.00	787,029,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,465,584,197.90</u>	<u>7,036,028,871.94</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,465,584,197.90</u>	<u>7,036,028,871.94</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,465,584,197.90	7,036,028,871.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	794,950,269.92	794,950,269.92
51101	Өмч: - төрийн	794,950,269.92	794,950,269.92
512	Хуримтлагдсан үр дүн	2,808,946,878.81	2,379,391,552.85
51210	Өмнөх үеийн үр дүн	2,808,946,878.81	2,808,946,878.81
51220	Тайлант үеийн үр дүн	-	(429,555,325.96)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,861,687,049.17	3,861,687,049.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,465,584,197.90</u>	<u>7,036,028,871.94</u>

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,755,347,799.00	2,996,352,389.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	877,741,162.00	459,154,649.80
120	Нийтлэг татварын бус орлого	877,741,162.00	459,154,649.80
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	873,756,162.00	54,350,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	873,756,162.00	54,350,000.00
120009	Бусад орлого	3,985,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		90,317,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		314,487,149.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,877,606,637.00	2,537,197,740.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,783,228,500.00	2,411,988,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,783,228,500.00	2,411,988,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,378,137.00	125,209,240.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,493,887.00	38,233,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,146,750.00	42,042,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,737,500.00	44,933,840.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,900,609,479.53	3,425,907,715.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,900,609,479.53	3,425,907,715.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,896,981,183.53	3,420,922,924.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,507,691,890.00	2,113,261,766.00
210101	Үндсэн цалин	890,356,290.00	899,092,392.00
210102	Нэмэгдэл	579,220,600.00	1,156,660,374.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,115,000.00	38,115,000.00
210104	Урамшуулал	-	19,394,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,292,200.00	60,361,800.00
210201	Тэтгэврийн даатгал	27,522,900.00	17,583,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	22,872,100.00	2,068,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,407,600.00	1,655,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	489,600.00	413,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	38,640,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,202,300.00	107,844,398.00
210301	Гэрэл, цахилгаан	8,963,013.00	13,085,362.00
210302	Түлш, халаалт	72,804,757.00	91,176,100.00
210303	Цэвэр, бохир ус	2,434,530.00	3,582,936.00
2104	Хангамж, бараа материалын зардал	90,317,616.00	126,914,022.00
210401	Бичиг хэрэг	4,653,710.00	3,728,160.00
210402	Тээвэр, шатахуун	79,898,770.00	120,511,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,217,200.00	1,941,762.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,430,000.00	732,600.00
210408	Бараа материал акталсны зардал	2,117,936.00	-
2105	Нормативт зардал	155,411,457.00	226,136,591.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	863,320.00	58,080,600.00
210502	Хоол, хүнс	66,593,460.00	60,509,860.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	87,954,677.00	107,546,131.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,594,750.00	37,996,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	261,050.00	6,056,000.00
210604	Урсгал засвар	25,333,700.00	31,940,000.00
2107	Томилот, зочны зардал	29,455,800.00	31,574,600.00

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	29,455,800.00	31,574,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,222,829.00	30,836,783.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	738,200.00	19,200,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,932,400.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,117,100.00	1,130,239.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	612,400.00	1,009,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,269,715.00	3,437,600.00
210807	Газрын төлбөр	2,553,014.00	6,059,044.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	940,792,341.53	685,996,964.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,983,397.00	16,948,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,283,790.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элгэдэл, хорогдол	888,525,154.53	669,048,164.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,628,296.00	4,984,791.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,460,000.00	4,414,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,460,000.00	4,414,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,168,296.00	570,591.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,168,296.00	570,591.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(145,261,680.53)	(429,555,325.96)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	6,741,730.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	6,741,730.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,985,000.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	10,985,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,243,270.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(149,504,950.53)	(429,555,325.96)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,877,606,637.00	2,537,197,740.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,877,606,637.00	2,537,197,740.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,783,228,500.00	2,411,988,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,783,228,500.00	2,411,988,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,378,137.00	125,209,240.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,493,887.00	38,233,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,146,750.00	42,042,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,737,500.00	44,933,840.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,877,606,637.00	2,536,298,740.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,877,606,637.00	2,536,298,740.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,871,934,941.00	2,531,313,949.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,507,691,890.00	2,113,261,766.00

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	890,356,290.00	892,246,866.00
210102	Нэмэгдэл	579,220,600.00	1,163,505,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,115,000.00	38,115,000.00
210104	Урамшуулал	-	19,394,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,292,200.00	60,361,800.00
210201	Тэтгэврийн даатгал	27,522,900.00	17,583,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	22,872,100.00	2,068,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,407,600.00	1,655,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	489,600.00	413,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал		38,640,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,706,800.00	107,784,898.00
210301	Гэрэл, цахилгаан	9,592,600.00	13,157,362.00
210302	Түлш, халаалт	74,495,000.00	91,044,600.00
210303	Цэвэр, бохир ус	2,619,200.00	3,582,936.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,620,650.00	43,015,562.00
210401	Бичиг хэрэг	2,407,700.00	1,949,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,555,750.00	38,391,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,227,200.00	1,974,762.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,430,000.00	700,800.00
2105	Нормативт зардал	61,794,910.00	54,765,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	568,000.00	1,880,400.00
210502	Хоол, хүнс	61,226,910.00	52,885,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,996,300.00	25,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,021,300.00	-
210604	Урсгал засвар	21,975,000.00	25,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	29,455,800.00	31,574,600.00
210702	Дотоод албан томилолт	29,455,800.00	31,574,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,360,714.00	45,130,883.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,580,200.00	33,494,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	3,932,400.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,117,100.00	1,130,239.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	612,400.00	1,009,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,565,600.00	3,437,600.00
210807	Газрын төлбөр	2,553,014.00	6,059,044.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,015,677.00	50,419,040.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,741,477.00	50,419,040.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,274,200.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,671,696.00	4,984,791.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,503,400.00	4,414,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,503,400.00	4,414,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,168,296.00	570,591.00

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,168,296.00	570,591.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	899,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	899,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	899,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	899,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		899,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(899,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,928,249.17	2,323,578,920.65		6,980,457,439.74
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	2,958,451,829.34	0.00	7,615,089,148.43
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-149,504,950.53		-149,504,950.53
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	2,808,946,878.81	0.00	7,465,584,197.90
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	2,808,946,878.81	0.00	7,465,584,197.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		0.00			0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	2,808,946,878.81	0.00	7,465,584,197.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-429,555,325.96		-429,555,325.96
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	2,379,391,552.85	0.00	7,036,028,871.94

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,411,988,500.00	2,411,417,909.00	570,591.00	99.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,411,988,500.00	2,411,417,909.00	570,591.00	99.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,407,574,300.00	2,407,003,709.00	570,591.00	99.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,113,455,300.00	2,113,261,766.00	193,534.00	99.99
210101	Үндсэн цалин	917,440,400.00	892,246,866.00	25,193,534.00	97.25
210102	Нэмэгдэл	1,138,505,900.00	1,163,505,900.00	(25,000,000.00)	102.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,115,000.00	38,115,000.00	-	100.00
210104	Урамшуулал	19,394,000.00	19,394,000.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ш	60,361,800.00	60,361,800.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	17,583,800.00	17,583,800.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,068,500.00	2,068,500.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,655,100.00	1,655,100.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	413,700.00	413,700.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,640,700.00	38,640,700.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,982,300.00	107,784,898.00	197,402.00	99.82
210301	Гэрэл, цахилгаан	13,164,600.00	13,157,362.00	7,238.00	99.95
210302	Түлш, халаалт	91,044,600.00	91,044,600.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	3,773,100.00	3,582,936.00	190,164.00	94.96
2104	Хангамж, бараа материалын зардал	4,280,400.00	4,255,562.00	24,838.00	99.42
210401	Бичиг хэрэг	1,580,000.00	1,580,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,999,600.00	1,974,762.00	24,838.00	98.76
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,800.00	700,800.00	-	100.00
2105	Нормативт зардал	51,208,800.00	51,208,800.00	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	278,400.00	278,400.00	-	100.00
210502	Хоол, хүнс	50,930,400.00	50,930,400.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,000,000.00	25,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	25,000,000.00	25,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний т	45,285,700.00	45,130,883.00	154,817.00	99.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үй	33,494,500.00	33,494,500.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,152,200.00	1,130,239.00	21,961.00	98.09
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,141,800.00	1,009,500.00	132,300.00	88.41
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,437,600.00	3,437,600.00	-	100.00
210807	Газрын төлбөр	6,059,600.00	6,059,044.00	556.00	99.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,414,200.00	4,414,200.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,414,200.00	4,414,200.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,414,200.00	4,414,200.00	-	100.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,411,988,500.00	2,411,417,909.00	570,591.00	99.98
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,411,988,500.00	2,411,417,909.00	570,591.00	99.98
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,411,988,500.00	2,411,417,909.00	570,591.00	99.98
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	112	109	3	97.32
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	101	98	3	97.03
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	-	100.00

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	125,209,240.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,209,240.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	125,209,240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,760,000.00
210401	Бичиг хэрэг	369,000.00
210402	Тээвэр, шатахуун	38,391,000.00
2105	Нормативт зардал	3,556,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,602,000.00
210502	Хоол, хүнс	1,954,600.00
2107	Томилолт, зочны зардал	31,574,600.00
210702	Дотоод албан томилолт	31,574,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,318,040.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,318,040.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	125,209,240.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	125,209,240.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,233,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,042,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,933,840.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газар нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гамшгаас учирсан хор уршгийг арилгах, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, сэргээн босгох чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Зорилго нь аймгийн хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх замаар иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Тус газар 2023 онд 3 зорилт дэвшүүлж ажилласан байна. Үүнд:

- Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах.
- Штабын бэлтгэл, ажиллагааны удирдлагын чадавхыг бэхжүүлэх
- Холбоо зарлан мэдээлэл, цахим ашиглалтыг нэмэгдүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Аймгийн Онцгой байдлын газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай хууль Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузел суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

ОБЕГ-ын даргын 2016 оны А/293 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 429.5 сая төгрөгөөр буюу 5.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	40,000.0	54,000.0	14,000.0
Урьдчилгаа			
Бараа материал	1,182,662.5	1,262,588.8	79,926.3
Үндсэн хөрөнгө	6,242,921.7	5,719,440.1	(523,481.6)
Нийт хөрөнгө	7,465,584.2	7,036,028.9	(429,555.3)
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,465,584.2	7,036,028.9	(429,555.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,465,584.2	7,036,028.9	(429,555.3)

Урьдчилгаа дансны авлага 14.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Цамбагарав Өгөөж ХХК-аас авах орон сууцны урьдчилгаа байна.

Бараа материалын данс 79.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 160.0 сая төгрөгийн бараа материал худалдан авч, ОБЕГ-ын харьяа 115 дугаар ангиас 173.3 сая төгрөгийн хувцас хэрэглэл, тусгай зориулалтын материал, хүнсний материал, ОБЕГ-аас 84.7 сая төгрөгийн картын шатахууны талон, баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газраас 55.0 сая төгрөгийн ковидын үеийн оношлуур, ОБЕГ-ын харьяа улсын нөөцийн газраас 1.3 сая төгрөгийн пост төхөөрөмж, нийлүүлсэн, 394.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 523.5 сая төгрөгөөр буурсан нь 105.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, үндсэн хөрөнгөд 669.4 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан холбоотой байна.

ОБЕГ-ын дэргэдэх 185 дугаар ангиас 12.0 сая төгрөгийн 2 ком таван ханатай иж бүрийн гэр, 78.0 сая төгрөгийн фургон автомашин, албан хаагчдын санаачилгаар /хандиваар/ 15.9 сая төгрөгийн хүндэтгэлийн өргөө, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 38.4 сая төгрөгийн шалган нэвтрүүлэх байр барьж байгуулсныг орлого авсан байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 429.5 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,459.6 сая төгрөг, нийт зарлагыг 2,459.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 541.8 сая төгрөгөөр бууруулж, 1,917.8 сая төгрөгөөр баталсан боловч тайлант онд төсвийн тодотгол хийгдэж 494.0 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 494.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,411.9 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,411.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 0.6 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,411.4 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 0.6 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70708	Гамшгаас урьдчилан сэргийлэх	2,411,988.5	2,411,417.9	570.6	99.9
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,407,574.3	2,407,003.7	570.6	99.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	4,414.2	4,414.2	-	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ОБЕГ-аас гамшиг ослын томилолт болон бусад санхүүжилтэд 42.0 сая төгрөгийн, аймгийн Засаг даргын дэмжлэгээс 45.0 сая төгрөгийн санхүүжилт авч, ИНЕГ-тай хийсэн гэрээний дагуу 38.3 сая төгрөгийн орлого оруулж, Санхүү, төрийн сангийн хэлтсээс нээж өгсөн эрхийн дагуу бараа, үйлчилгээний бусад зардал, албан томилолт болон бусад зардлуудад зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Онцгой байдлын газар 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аймгийн Онцгой байдлын газар нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 160.0 сая төгрөгийн бараа материал, 0.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 19/18 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2,900.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 29.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус газар нь батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулж, жилийн эцэст өр, авлагагүй ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 2,499.0 төгрөгийн 26 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 118.3 төгрөгийн 15 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчил илрээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 784,136.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 784,136.6 мянган төгрөгийн алдааг залруулсан.

- Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны тайлант оны үр дүнг 784,136.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Аудитаар нийт 18,010.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 18,010.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй

5.2 Албан шаардлага

Байхгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим төлбөрийн баримттай тулгалт хийхэд түлш халаалтын зардлаас 4,4 сая төгрөгийн 4 гүйлгээ, хоолны зардлаас 7.5 сая төгрөгийн 4 гүйлгээ, урсгал засварын зардлаас 1.2 сая төгрөгийн 2 гүйлгээ нийт 13.1 сая төгрөгийг цахим төлбөрийн баримтгүй шилжүүлсэн, Нэмэлт төсвөөс 4.8 сая төгрөгийн албан томилолтыг бүрдэл дутуу баримтаар олгосон байна.

Энэ нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 -д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т” албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5-дахь заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтын цахим төлбөрийн нэхэмжлэлийн баримтыг бүрэн бүрдүүлж гүйлгээ хийх, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмчийн өөрчлөлтийн тайланд үр дүнг зөрүүтэй тайлагнасан	1	784,136.6			1	784,136.6	1	784,136.6				
Дүн	1	784,136.6			1	784,136.6	1	784,136.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бүрдэл дутуу баримтаар	1	18,010.0					1	18,010.0				

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

гүйлгээ хийсэн												
Дүн	1	18,010.0					1	18,010.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								